**УЛААНБААТАР ХОТ НАЛАЙХ ДҮҮРЭГ 6-Р ХОРООНЫ ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН НУТАГТ БАЙРЛАХ “ТҮМЭН ХААН” РЕСОРТ АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ЦОГБОЛБОР ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АГУУЛГА


БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ..... 2
1.1 Төслийн нэр: ..... 2
1.2 Төслийн зорилго: ..... 2
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл: ..... 2
1.4 Төслийн хүчин чадал ..... 2
1.5 Төслийн дэд бүтэц: ..... 3
1.5.1 Цахилгаан хангамж: ..... 3
1.5.2 Усан хангамж: ..... 3
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ..... 5
2.1 Төслийн байршил:п ..... 11
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 12
3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө: ..... 13
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөө: ..... 13
3.5 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл: ..... 13
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ ..... 15
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 17
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 20
БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 21
БҮЛЭГ 9. ХОГ, ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 22
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ..... 23
БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 24
БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ..... 25


## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1 Цахилгаан хангамж ..... 3
Зураг 2 Худгийн тоолууржуулсан байдал ..... 4
Зураг 3 Худгийн байршил ..... 4
Зураг 4 Боловсон нойл ..... 6
Зураг 5 Бохирын систем ..... 7
Зураг 6 Суурилуулалтын үеийн байдал ..... 7
Зураг 7 Суурилуулалтын үеийн байдал ..... 8
Зураг 8 Төслийн байршил ..... 11
Зураг 9 Нөлөөллийн эрчмийн зураг ..... 12


## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл ..... 2
Хүснэгт 2 БОМТ нийт зардал ..... 15
Хүснэгт 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө ..... 17
Хүснэгт 4 Орчны тохижилт, цэцэржүүлэлтийн төлөвлөгөө ..... 20
Хүснэгт 5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө ..... 21
Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө ..... 22

Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр ........ 23
Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтийн төлөвлөгөө ........ 24

# БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төслийн нэр:

“Түмэн хаан” ресорт аялал жуучлалын бааз

## 1.2 Төслийн зорилго:

Налайх дүүргийн 6-р хорооны Горхи-тэрэлжийн БЦГ-т орших түмэн хаан ресорт нь 2017 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ батлуулсан бөгөөд уг үнэлгээний тайлангийн хуулийн хугацаа хийсэн тул шинэчилж хийх зорилготой

## 1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл:

Хүснэгт 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | “Алтан Тур” ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011098031 |
| Регистрийн дугаар | 2703181 |
| Хаяг | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг 1-р хороо, 12-р хороолол, 47-7 тоот |
| Утас | 99086928 |

## 1.4 Төслийн хүчин чадал

Тус бааз нь төслийн хүрээнд:

- Задгай кино театр
- Авто зогсоол
- Тайз
- Спорт талбай
- Автомашины граж
- Шорлогийн талбай
- A,B,C блок
- Дугуйн амралтын талбай зэргийг нэмж байгуулахаар төлөвлөсөн байна.

“Түмэн Хаан” бааз нь ерөнхий төлөвлөгөөний дагуу 2022оны 9 сарын 12-ны байдлаар нийт 32 ширхэг гэрийг амралт үйлчилгээний зориулалтаар ашиглаж байна

- 2 ортой 1 ширхэг гэр
- 3 ортой 10 гэр
- 4 ортой 19 гэр
- 5 ортой 2 гэр

- 10 ортой 1 гэр

## 1.5 Төслийн дэд бүтэц:

### 1.5.1 Цахилгаан хангамж:

“Алтан тур”ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны Горхи-Тэрэлжийн нутагт орших “Түмэн хаан ресорт” төслийн талбай нь цахилгаан эрчим хүчний хэрэглээг төвийн эрчим хүчний шугам сүлжээнээс татан авч, бууруулах трансформатороор дамжуулан авч хангадаг.



Зураг 1 Цахилгаан хангамж

### 1.5.2 Усан хангамж:

Тус төслийн талбай нь усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. Улаанбаатар хотын Эрдэнэдрийлинг компанийн супер 6000 маркийн станокоор 70м гүнтэй, 1.2л/сек ундарга бүхий худгийн цооногийг 2007 оны 11 сарын 26 батлуулсан байна.

Эзэмшигч иргэн: Б. Цэцэгмаа

Худаг гаргасан аж ахуйн нэгж: “Эрдэнэдрийлинг”ХХК

Худгийн байршил: 107023I32,57E , 47058I48,34N




**Зураг 3 Худгийн байршил**



Зураг 2 Худгийн тоолууржуулсан байдал

# БҮЛЭГ 4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог.

## 4.1 Төсөл хэрэгжих талбайгаас үүсэх хатуу хог хаягдал

Ажилчдын өдөр тутмын үйл ажиллагааны явцад ахуйн хог хаягдал гарна. Мөн төслийн талбайн цайны газраас хоол хүнсний зүйлийн үлдэгдэл, баглаа боодол зэрэг хатуу хог хаягдал гарах болно

Хог хаягдлын тооцоо: Тус төсөл нь өдөрт дунджаар 50 хүртэл зочид хүлээн авах чадалтай ба энэ хүчин чадлаараа ажиллавал баазын үйл ажиллагаанаас гарах хатуу хог хаягдлын хэмжээг хоногт 30кг, сард 0,9 тн орчим байна гэж тооцож гаргасан.

Дээрх тооцоог 1 хүн өдөрт дунджаар 0,6 кг хатуу хог хаягдал гаргана хэмээн тооцоололд үндэслэн хийв. Байнгын ажилчид төслийн байгууламжийн үйл ажиллагаа улирлаас үл хамааран ажиллах тул ажилчид жуулчдын хэрэглээнээс сард гарах 900кг хатуу хог хаягдлыг тооцоонд багтаан тусгасан болно.

Тус төслийн үйл ажиллагаагаар ялгаран гарсан хатуу хаягдлыг Төсөл хэрэгжүүлэгч нь 2023 оны 06 сарын 15-ны өдөр Налайх дүүргийн “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын газартай хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх үйлчилгээний гэрээг хавсаргав.

**Зөвлөмж:** Төсөл хэрэгжүүлэгчид төслийн талбайн гадна талбайд дээрх хог хаягдлыг ангилан ялгах савыг судлан гадна талбайд байрлуулахыг зөвлөж байна. Мөн төслийн үйл ажиллагаа хэрэгжих үед баримтлах хог хаягдлын менежмент нь Хог хаягдлын тухай /2017/ зэрэг хог хаягдалтай холбоотой хууль дүрэм журмуудыг мөрдөн ажиллах нь зүйтэй.

## 4.2 Шингэн хог хаягдал

Төслийн үйл ажиллагаанаас ахуйн шингэн хаягдал (хоол хүнсний хаягдал, угаалга, цэвэрлэгээний хаягдал бохир ус зэрэг) гарна.

| Хоногийн усны хэрэглээ, норм $м^3$ | Ажилчдын тоо | Хоногийн усны хэрэглээ, $м^3$ | Сарын усны хэрэглээ, $м^3$ | 70% хаяна гэж үзвэл |
|---|---|---|---|---|
| 0.15 | 10 | 1.5 | 45 | 1.05 |

- ✓ Ажилчдын шингэн хог хаягдал: Тус бааз нь 10 ажилчидтай ба хоногт дунджаар 1.5$м^3$ сард 45 $м^3$ орчим ус хэрэглэхээр байна. Үүний 70% - ийг хаяна гэж үзвэл 1.05 $м^3$ шингэн хаягдал гарахаар байна.

Дээрх тооцоог 1ажилчин өдөрт 150л ус хэрэглэнэ гэсэн тооцоололд үндэслэн хийв.

| Хоногийн усны хэрэглээ, норм $м^3$ | Жуулчдын тоо / дунджаар / | Хоногийн усны хэрэглээ, $м^3$ | Сарын усны хэрэглээ, $м^3$ | 70% хаяна гэж үзвэл |
|---|---|---|---|---|
| 0.02 | 50 | 1 | 30 | 0.7 |

- ✓ Жуулчдын шингэн хог хаягдал: Тус баазад өдөрт дунджаар 50 жуулчид ирнэ гэж үзвэл хоногт 1$м^3$ сард 30 $м^3$ орчим ус хэрэглэхээр байна. Үүний 70% - ийг хаяна гэж үзвэл 0.07 $м^3$ шингэн хаягдал гарахаар байна

Дээрх тооцоог 1 жуулчин өдөрт 20л ус хэрэглэнэ гэсэн тооцоололд үндэслэн хийв.

**Зөвлөмж**: Төслөөс гарах шингэн хог хаягдлыг “Алтан тур” ХХК нь цэвэрлэх байгууламж байгуулан байгаль орчинд халгүй арга хэлбэрээр зайлуулах, дахин ашиглах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн “Ус бохирдуулсны төлбөрийн тухай” хуулийн 2019 оны 05 сарын 02 нд батлагдсан нэмэлт өөрчлөлтийг, Усны тухай хууль, Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6734:2018 стандарт зэргийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллахыг зөвлөж байна. Төсөл хэрэгжүүлэгч нь доорх цэвэрлэх байгууламжуудаас сонгон үйл ажиллагаандаа суурилуулахыг зөвлөж байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Алтантур” ХХК нь 2023 оны 6 дугаар сарын 8 ны өдөр “Пумбо хөгжил” ХХК бохир тээвэрлэх гэрээг хийсэн байна. Мөн 6 сарын 12 болон 27 өдрүүдэд бохирыг соруулсан.

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаандаа боловсон нойлыг шийдэж өгсөн байна.



Зураг 4 Боловсон нойл

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж "Алтантур" ХХК нь үйл ажиллагаандаа Юниклос бохирын системийг 2022 оны 9 сард суурилуулсан байна.



Зураг 5 Бохирын систем

Тус системийг ОХУ-д үйлдвэрлэсэн, биологийн цэвэрлэгээ хийгдээд 4 камер дамжаад 98% цэвэршүүлээд байгальд шингэж байгаа ба жилд 1 удаа ирж сервис үйлчилгээгээ хийж хариуцна.

- Станц суурилуулах элсэн суурийн түвшин : Дүүрэн тэгш
- Станц суурилуулалтын түвшин: Тэгш
- Насос, компрессорын үйл ажиллагаа: Хэвийн бүрэн шалгасан
- Туршилтын урсац: Хэвийн



Зураг 6 Суурилуулалтын үеийн байдал



Зураг 7 Суурилуулалтын үеийн байдал

Мөн тус бохирын систем нь хүчин чадал багатай учир нэмэгдүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй.

**Хог хаягдлын ангилан ялгалт хийх зөвлөмж:**

Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дахин ашиглагдах, энгийн аюултай гэсэн ангиллаар ялгаж төрөл төрлөөр нь зориулалтын хогийн цэгт төвлөрүүлэх буюу устгалд оруулах шаардлагатай. Иймд доорх хүснэгтэд заасанчлан хогийн савнуудыг байрлуулж, саванд хаяг, пайз хадан түүндээ хог хаягдлаа ангилан ялгах нь зүйтэй.

Төслийн үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн хог хаягдлын цэгийг сонгохдоо салхины зонхилох чиглэлийн доор дүүргийн БО-ны байцаагчийн тогтоосон цэгт байгуулж, төслийн үйл ажиллагаанаас гарах нийт хог хаягдлын дахин ашиглагдах хаягдлуудыг

ангилан ялгах, овор хэмжээг нь багасгах зэргээр байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг бага байлгах шаардлагатай. Ахуйн хог хаягдлыг ангилсан тохиолдолд түүний шил, металл зэргийг төв суурин газарт тээвэрлэн хүргэж, хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт борлуулж байх нь зүйтэй.

Мөн хогийн сав нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

- ✓ Хог хаягдлыг ангилах, ачиж цуглуулах технологид нийцсэн
- ✓ Галд тэсвэртэй материалаар хийгдсэн
- ✓ Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн байх шаардлагатай.

Ахуйн гаралтай бусад хог хаягдлыг зайлуулах гэрээг дүүргийн удирдлагатай хийж, гэрээний дагуу тогтмол хугацаанд тээвэрлэж нэгдсэн цэгт зайлуулах шаардлагатай

**Хог хаягдлын хадгалалт, зайлуулагчаас үүдэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж:**

- Төсөл хэрэгжих үед үүсэх хог хаягдлыг түр хадгалах цэгийг норм журмын дагуу зохион байгуулах
- Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан төслөөс үүсэх хог хаягдлыг төвлөрсөн нэг цэгт тээвэрлэн устгах,
- Хаягдлыг тухай бүрд нь цуглуулж ил задгай тархахаас сэргийлэх,
- Хатуу хаягдлыг зайлшгүй ялган зохих хэсгүүдийг (цаас, хуванцар, шил, төмөр төмөрлөгүүд, хүнсний органик хаягдал г.м) хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилан ялгах хэсгийн тусгай уут саванд хадгалах, ангилсан хаягдал агуулах нэмэлт хогийн савнууд суурилуулах
- Ажилчдад ил задгай хог хаяхгүй байх заавар зөвлөмжийг тогтмол өгч сануулж байх
- Хог хаягдлын цэгт тогтмол ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байх
- Эрүүл ахуйн, ариун цэврийн шаардлага стандартыг мөрдөх
- Хогийн сав болон хог хаях цэгийн багтаамж, хүчин чадлаас хамааран тогтсон хуваарийн дагуу хог хаягдлын цэгт тээвэрлэн нэгдсэн цэгт хаях
- Хог хаягдлыг зайлуулах төвлөрсөн цэгийн эргэн тойронд хашаа хамгаалалт хийх, хогийг тогтмол шууж бөөгнүүлэн түүний эзлэх талбайг багасгах

Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS5344:2003 Ахуйн хог хаягдал тээвэрлэлт ангилал Ерөнхий шаардлага стандартыг баримтлана.

Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байна.

- Дахин ашиглах болон шатааж болох боломжтой хог хаягдал

Төрөл бүрийн цаас, картон цаас, шингэний тетропак савалгаа, хуванцар сав, сав баглаа боодол, хөнгөн цагаан, метал, зэс, гууль сав, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал гялгар уут

- Бусад хог хаягдал

Үнс, түргэн муудах хоол, хүнсний хаягдал, ариун цэврийн хэрэглэлийн хаягдал дахин ашиглагдах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хог хаягдал

**Дахин боловсруулан ашиглах боломжтой хог хаягдлын зөвлөмж:**

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаас байгаль орчин, хөрсөнд шингэдэггүй хоёрдогч түүхий эдийг ангилан ялгаж, дахин боловсруулалт хийн анхан шатны болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тухайлбал: Хаягдал хуванцрыг дахин боловсруулж гялгар уут, хуванцар сандал, моторын тосыг дахин боловсруулж дизель түлш үйлдвэрлэдэг.

# БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## 2.1 Төслийн байршил:

Төсөл хэрэгжих талбай нь 9111098031 нэгж талбарын дугаартай 5га газрыг хамран оршино. Улаанбаатар хотын Налайх дүүргийн 6-р хорооны нутаг дэвсгэрт Горхи-Тэрэлжийн БЦГ-д орших бөгөөд Улаанбаатар хотоос 70км Налайх дүүргээс 31 км зайд оршино.




Зураг 8 Төслийн байршил

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Монгол улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ний өдрийн А-117 дугаарт тушаалын 2 дугаар хавсралт Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлалын 3.3.2 дэх хэсгийн дагуу “Аялал жуулчлалын бааз” төслийн зураг төсөл, хөрс, усны шинжилгээний дүн, ландшафт болон төсөл хэрэгжүүлэх газрын байгаль орчны төлөв байдал, нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, сум орон нутгийн хөгжлийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийг үндэслэн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, тусгай хамгаалалттай газар нутаг болон төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл зэргийг магадлан жагсаах арга буюу хяналтын хуудасны арга ашиглан тодорхойллоо. Мөн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгав. Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний судалгаа, гол болон болзошгүй нөлөөллийг тогтоох, түүнд үнэлгээ өгөхөд ашигласан арга, загварчлал, тооцооллын үр дүнг тусгалаа.




Зураг 9 Нөлөөллийн эрчмийн зураг

**3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөө:**

- Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий
- Тоос, тоосонцор нь тунадасжин бууж хөрс, гүний усанд орж тархах, бохирдуулах
- Тоосжилт ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх

**3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөө:**

- Тээврийн хөдөлгөөнөөс хөрсний эвдрэл үүсгэх
- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадарга эвдэгдэх
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Тоос хөрсөнд хуримтлагдаж бохирдол үүсэх

**3.4 Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөө:**

- Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор ургамлан нөмрөг талхлагдах
- Тээврийн хөдөлгөөнөөс үүсэх тоосжилт ургамлан нөмрөгт дам нөлөөлөл үзүүлэх
- Барилгын ажлын үед үүсэх барилгын хог хаягдалд ургамлан нөмрөг талхлагдах

**3.5 Гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл:**

- Газрын доорх усны нөөц хомсдох,
- Орчны тоосжилт бууруулахад ус ашигласны улмаас усны нөөц хомсдох
- Гадаргын усны урсац, голдирлыг өөрчлөх
- Төслийн талбайн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хог хаягдлыг зайлуулаагүйн улмаас хог хаягдал гадаргын болон газрын доорх усыг бохирдуулахп

**Магадлан жагсаах аргаар үнэлэх:** Энэ арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм. Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимжил зэргийг тодорхойлохын тулд магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар хэрэгждэг.

Магадлан жагсаах арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал “х”-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

“Түмэн хаан” ресорт төслийн явцад төсөл хэрэгжих орон нутгийн байгаль орчны төлөв байдал, биологийн олон янз байдал, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжил, нутгийн иргэдийн эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар гүйцэтгэн доорх хүснэгтэд харууллаа.

# БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Аялал жуулчлалын цогцолбор” үйлчилгээний төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хууль, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал”, Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”–ын 2-р хэсэгт тусгасаны дагуу, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэрэгт тулгуурлан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах хянан батлах, тайлагнах журам”- ын дагуу боловсруулав Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Алтантур” ХХК -аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

Хүснэгт 2 БОМТ нийт зардал

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө | Зардал (сая.төг) |
|---|---|---|

| | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө | |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 350.0 |
| 2 | Орчны тохижилт, цэцэржүүлэлтийн төлөвлөгөө | 250.0 |
| 3 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 350.0 |
| 4 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 300.0 |
| 5 | Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө | 100.0 |
| | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 150.0 |
| | 2023 оны нийт зардал | 1.500.000 |

Тус төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин болон төслийн ажилчид, ойр орчмын оршин суугчид, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, тухайн орчныг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тус төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэхэд оршино Ингэхдээ, төсөл хэрэгжүүлэгч тухайн арга хэмжээ бүрийг хэрэгжүүлж болохуйц, бодиттой арга хэмжээг төлөвлөн тусгахыг эрхэм болголоо. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны 1 жилийн хугацаанд менежментийн төлөвлөгөөний ажилд нийт **1.500.000** төг зарцуулахаар төсөвлөгдсөн байна.

# БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (мян.төг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Агаарын чанар | | | | | | | |
| 1 | Тоос ихээр боссон тохиолдолд | Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, яндланд шүүлтүүр тавих | Үйл ажиллагааны хүрээнд | _ | 33.0 | _ | 33.0 | Жил бүр | Агаарын тухай хууль, - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2015, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) -“Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага” MNS 5078: 2001 |
| | | Усалгаа арчилгаа, тордолт хийх | Үйл ажиллагааны хүрээнд | _ | _ | _ | _ | 2023 оны 5-7 сар | |
| | | Хөрсөн бүрхэвч | | | | | | | |
| | | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэх | Төслийн талбайд | _ | Жилд 1 удаа | Гэрээний дагуух төлбөр | | 2023 онд | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хөрсний эвдрэл, гэмтэл | Орчны тоосжилт болон салхины хурд, дуу чимээг бууруулах болон салхинаас хамгаалах зорилгоор мод бут тарих | Үйлдвэрийн хүрээнд | – | – | – | – | Тогтмол | химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | | Төслийн талбай дахь гадна, дотор байрлуулсан бүх хогийн савыг өдөр бүр суллан цэвэрлэж байна | Үйл ажиллагааны турш | – | | | | | |
| 3 | БЦГ орчмын авто тээврийн хөдөлгөөн ихэссэнээс агаар дахь тоосны хэмжээ CO, SO2, NO2 ихсэж, орчны хүчилтөрөгчийн /O2/ хэмжээ багасах, үйлчлүүлэгч иргэд, аялагчдын автомашины шатах тослох материалын уршилт, утаа тортог, хорт хий агаарт дэгдэж агаар орчин бохирдуулах, | Хог хаягдал хадгалах зориулалтын цэг байгуулах | | | | | | | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| | | Төсөл хэрэгжих талбайн сул чөлөөтэй талбайг ургамалжуулах, тохижуулах | | | | | | | |
| | | Төслийн орчны авто замд тэмдэгжүүлэх ажил хийх, төслийн хашаанаас гадна талбайд олон салаа зам гаргахаас сэргийлэх | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэж болно. - Барилга байгууламж барих үеийн газар шорооны ажлаас тоосжилт үүсэх | | | | | | | | |
| | | Ургамлан нөмрөг | | | | | | | |
| 4 | Зонхилох ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, талхагдал өөрчлөл | Төслийн төлөвлөгөөнд тусгагдсан талбайд мод, бут сөөг тарьж, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Үйлдвэрийн ажиллагсад | – | 160.0 | 160 ажилчид | 160.0<br>/ 500ш / | 2023 онд | MNS12-4-005 : 1985<br>Шуугианаас хамгаалах хэрэгсэл ба аргууд. Ангилал. |
| | | Ургамлын монитронгийн цэг байгуулан жил бүр тогтмол мониторинг хийх | Үйлдвэрийн ажиллагсад | – | | | | 2023 онд | MNS 6768:2019 стандартын шаардлагын дагуу хувь хүний сонсголын түвшинд хийгдсэн байна. |
| | Нийт 350.0 | | | | | | | | |

# БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4 Орчны тохижилт, цэцэржүүлэлтийн төлөвлөгөө

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний цар хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал мян,төг | Хэрэгжүүлэх хугцаа ба давтамж | Баримтлах эрх зүй баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төслийн талбайд ногоон байгууламжтай болсоноор агаарын тоосжилт буурах зорилттой / Тэрбум мод төслийг хэрэгжүүлэх/ | Төслийн талбайн арын хэсгийн сул талбайг ногоон байгууламж болгох | Төслийн талбай | – | – | | | Үйл ажиллагааны явцад | MNS 3985:1987 Байгаль хамгаалал. Хөрс. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл |
| | | Явган хүний зам дугуу хэсгийг зүлэгжүүлэх | Төслийн талбай | – | – | | | Үйл ажиллагааны явцад | |
| | | Гэрэлтүүлэг нэмэх | Төслийн талбайн гадна | – | – | | | Үйл ажиллагааны явцад | Ажлын байран дахь гэрэлтүүлэгийн хэмжилт,зөвшөөрөх хэмжээнд тавих шрөнхий шаардлага MNS 6767:2019 |
| | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд 100 ширхэг мод тарих | Төслийн талбай | | | | | | |
| Нийт 250.0 | | | | | | | | | |

# БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах жрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх | Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх галын сараа байгуулах | Үйлдвэр болон агуулах | 5ш | 30.0 | 150.0 | Жил бүр | Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1, - MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага - MNS4995:2000. ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага |
| | | Гэнэтийн ослоос урьдчилан хамгаалах төлөвлөөгөөтэй байх | Бүх ажилчид | 160 | 25 | 4000.0 | 2023 он | |
| | | Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах | Үйлдвэр болон агуулах | - | 25.0 | 100.0 | 2023 он | |
| | | Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах | Төслийн талбай | _ | Үйл ажиллагааны зардлаар | 2023 | 2023 он | |
| Нийт 350.0 | | | | | | | | |

# БҮЛЭГ 9. ХОГ, ХЯГДЛЫН МЕНЕЖМЕНИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

| № | Хог хаягдал ангилах | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал, төг | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хог хаягдал | Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх | 1ш Үйлвэр болон 2ш агуулахын хүрээнд | - | 50,0 | 9 удаа | 450,0 | 2023онд | Хог хаягдлын тухай хууль |
| | | Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, үйлчилгээний гэрээг Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний газартай хийх | | | | | | | |
| | | Хог хаягдлыг тухай бүрд тээвэрлэж зайлуулж байх | Төслийн талбайд | - | 200., | - | 200 | Үйл ажиллагааны хугацаанд | |
| | | Гадна талбайд хогийн сав байрлуулах | | | | | | Үйл ажиллагааны хугацаанд | |
| | | Бохирын цооногийн орчны ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийх | Төслийн хүрээнд | | | | | 2023онд | |
| | | Бохирын цооногийн орчны ариутгал халдваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийх | Төслийн хүрээнд | | | | | Үйл ажиллагааны хугацаанд | |
| | Нийт 300.0 | | | | | | | | |

# БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 7 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналтын цэгийн байршил | Хугацаа ба давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Тайлбар | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрс | | | | | | | | |
| 1 | Хөрсний механик бүрэлдэхүүн | Төслийн талбайн нэг цэг сонгон хөрсний шинжилгэ хийлгэх. | 2023 он | Жилд 1 удаа | 70.0 | 70.0 | Хөрсийг агрохими, хүнд мяталл, эрүүл ахуй, механик бүрэлдэхүүний шинжилгээг хийлгэнэ | MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, |
| 2 | Хөрсний агрохимин үзүүлэлт | | | | | | | |
| 3 | Хөрсний хүнд металлын үзүүлэлт | | | | | | | |
| 4 | Хөрсний эрүүл ахуйн үзүүлэлт | | | | | | | |
| Усны шинжилгээ | | | | | | | | |
| 5 | Усны ерөнхий үзүүлнлт | Усны эх үүсвэрээр | 2023 | Жилд 1 удаа | 46.0 | 46.0 | Усны чанар pH, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ | MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналтбохирдол) |
| | Нийт 150.0 | | | | | | | |

# БҮЛЭГ 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтийн төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Харилцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2023он | | | | |
| | | | Сар 6 | Сар 7 | Сар 8 | | |
| 1 | Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх | - | + | - | + | Гүйцэтгэх захирал | БОМТ-нд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. |
| 2 | Өрөө бүр хог хаягдлын ангилан ялгах боломжтой хогийн сав байршуулах | | + | + | + | Менежер | |
| 3 | Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах | - | + | + | + | Менежер | |
| 4 | Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах | | | | | | |
| 5 | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын тайланг БОАЖГ-т хүргэн өгч байх | | 2 жилд 1 удаа | | | | |
| 6 | Авто замын зогсоол хийх | | | | | | |
| Нийт 100.0 | | | | | | | |

## БҮЛЭГ 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

